

Би бүхий л зүрхээрээ Танд талархана. Бурхдыг
өмнө Таныг би магтан дуулна. ²Таны ариун
сүмд хандан би мөргөж Хайр энэрэл, үнэний
тань улмаас Таны нэрд талархахын

«Үгийг Тунхагла

учир нь Алдар нэр бүхнээсээ өндөрт Амлалтаа
Та өргөмжилснийх. ³Дуудсан өдөрт минь Та
надад хариулав. Сэтгэлийг минь хүч чадлаар
зоригжуулав ⁴Аяа ЭЗЭН, амнаас тань гарах
үгийг сонсохдоо Газрын бүх хаан Танд таларх
Тэд ЭЗЭНий замуудын тухай дуулна Учир нь
ЭЗЭНий алдар аугаа. ⁶ЭЗЭН хэдийгээр өндөрт
байвч Дорд нэгнийг хардаг. Бардамнагчийг
Тэрээр холоос ч мэддэг. ⁷Хэдийгээр зовлон ша

МЭРИЛИН ХИККИ & САРА БОУЛИНГ

өмнөөс Та мутраа сунгах бөгөөд Баруун мутар
⁸ЭЗЭН миний төлөө гүйцэлдүүлнэ. Аяа ЭЗЭН,
Мутрынхаа бүтээгдэхүүнийг би эрхнэ



Үгийг Тунхагла

МЭРИЛИН ХИККИ & САРА БОУЛИНГ

Marilyn Hickey Ministries
P.O. Box 6598 - Englewood, CO 80155-6598

SPEAK THE WORD (Mongolian) by Marilyn Hickey
New updated version
Revised 2013 Edition
Copyright © 1982, 1983, 2013
by Marilyn Hickey & Sarah Bowling

Marilyn Hickey Ministries
www.marilynandsarah.org

Originally published in English as Speak The Word
ISBN 978-1-938696-93-0

ҮГИЙГ ТУНХАГЛА
Мэрилин Хикки
© 2018, Marilyn Hickey & Sarah Bowling

Библийн ишлэлийг:
АРИУН БИБЛИ
© 2004, 2011, 2013
Ариун Бичээс Нийгэмлэг

Монгол улсад хэвлэв



Үгийг тунхагла

Мэрилин Хикки



Хүний амьдралд хэл яриа шиг хүчирхэг зэвсэг, хүч гэж үгүй. Тэр байтугай, хэл яриа нь хүний амьдрал, үхлийг ч шийддэг гэж Сургаалт үгс номд хэлсэн. Хүний биеийг хэл гэдэг бяцхан эд эрхтэн жолооддог болохыг Иаков хэлдэг (Иаков 3-аар бүлэг). Усан онгоцыг залуур чиглүүлж, амгайгаар морийг залдаг шиг, хэл яриа ч хүний бодол, сэтгэл мэдрэмж, биеийг хөгжил цэцэглэл, амжилт руу төдийгүй, үүнээс ч аугаа сайн сайхан руу удирдах хүч болж чадна.

Гэхдээ нөгөө талаас хэл яриа нь хүний бие махбод, бодол сэтгэлгээ, сэтгэл мэдрэмжийг сүйтгэн, сүйрүүлж ч чадна. Завхарсан үгс биднийг тэр чигээр нь устгаж чадна. Учир нь үгс нь яг л сүлбэгч илд мэт байдгийг Дууллын зохиогч хэлдэг. Хүн үгээрээ бүхнийг галдан шатааж чадна. Учир нь үгээр там асдаг юм.

Ева буруу үг ярьсан учраас, Сатан санаандаа хүрчээ. Там нь хэлсэн үгээр л асдаг учраас, таны хэлсэн сөрөг үг бүр тамыг амилуулна. Тиймээс л Бурхан Иошуад (Иошуа 1:8):

“Хуулийн энэ номыг амнаасаа салгалгүй байж, өдөр шөнөгүй үүнийг бясалган, үүн дотор бичигдсэн бүхнийг сахин биелүүл. Тэгвэл чиний зам өөдөлж, чи амжилтад хүрэх болно” хэмээн айлджээ.

Иошуа ном дахь энэ богино ишлэл нь хамаг л хөгжил цэцэглэл, амжилтад хүргэх түлхүүр юм. Үнэндээ энэ нь Библи дээр амжилт гэдэг үг гардаг ганцхан тохиолдол билээ. Та Бурханы Үгийг ярьснаараа л амьдралынхаа тал бүр дээр амжилтад хүрнэ.

Тэгвэл биднийг, хайртай хүмүүсийг маань онилсон муу муухай үгсийг яах вэ? Тэр муу муухай үгс бидний амьдралд бас л тамыг асаах уу? Үүнд мөн л Бурханы Үг хариулдаг. Исаиа 54:17 дээр ингэж хэлжээ:

“Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг амжилт олохгүй. Шүүх дээр чиний эсрэг боссон хэл

бүрийг чи яллана. ЭЗЭНий зарц нарын өв нь энэ бөгөөд Тэдэнд Надаас зөвтгөл ирнэ” гэж ЭЗЭН зарлиг болгов.”

Таныг болоод таны хайртай хүмүүсийг онилсон ялын үгсийг Есүсийн нэрээр зэмлэн буруушаа. Гэхдээ хэлсэн эзнийг нь биш, таны зүг хэлэгдсэн хорон муу үгсийг нь зэмлэн буруушаа. Тэдгээр сөрөг үгс нь таныг хорлож чадахгүй.

Дайсныг өнөөдөр ял. Доор бичсэн амь амьдралын үгсийг өдөр бүр тунхагла. Хүнд хэцүү үедээ өдрийн гурав тунхагла. Бурханы Үг амьд бөгөөд ажилладаг. Хийгээд үз - та дурлах болно! Чангаар хэлэх нь чухал. Учир нь ингэснээрээ та дотоод сүнслэг хүндээ давхар хэлдэг. Ийнхүү та сүнсээр хүчирхэг болно. Итгэлээ үр нөлөөтэй байлга. Үгийг тунхагла, Үгийг тунхагла, Үгийг тунхагла.

“Амны минь үгс мэлмийд тань тааламжтай байх болтугай, Эзэн минь.”

МЭДЛЭГ БА ЦЭЦ УХААН

Би Ариун Нэгэнээр тослогдсон бөгөөд би бүгдийг мэднэ. Өнөөдөр Есүс миний

дотор цэц ухаан, зөвт байдал, ариусгал, авран сэргээлтийг авчирсан. Учир нь надад Христийн оюун ухаан бий. Би цэц ухаанаар гэрээ барьж, гэр маань ойлголтоор сүндэрлэнэ (1Иохан 2:20, 1Коринт 1:30, 1Коринт 2:16, Иаков 3:17, Сургаалт үгс 24:3).

Бурханы цэц ухаан нь дээрээс ирдэг учраас, Бурханы цэц ухаан өнөөдөр намайг нөмөрнө. Би Түүний цэц ухаант үгсийг хэлэхдээ, өөрийнхөө нөхцөл байдал дээр амар тайван, өршөөлийг авчирна. Өнөөдөр Ариун Сүнс намайг үнэнээр хөтлөж байгаа учраас, би харанхуйд тэмтчихгүй. Эзэн надад бүхий л тал дээр ойлголтыг өгсөн тул, надад Христийн оюун ухаан байгаа тул цэц ухаан, мэдлэг миний цаг хугацааг цогцлооно (Иаков 3:17, Иохан 16:13, 1Коринт 1:30, 2Тимот 2:7, Исаиа 33:6, 1Коринт 2:16).

Бурхан надад дайсан эсэргүүцэж, хориглож чадахааргүй үг болоод мэргэн ухааныг өгсөн учраас, Сатан намайг ялж чадахгүй (Лук 21:15).

Хаанчлалын нууцыг мэдэх нь надад

зөвшөөрөгдсөн учраас, би таг харанхуйд алхахгүй. Эзэн миний явах ёстой замыг надад зааж, зааварладаг: Тэрбээр намайг мэлмийгээрээ хөтлөдөг (Матай 13:11, Ром 1:19, Дуулал 32:8).

Өнөөдөр би бүхий л сайн сайхан, бүхий л мэдлэг, ахан дүүстээ туслах чадвараар дүүрэн байна. Би Бурханы мэлмийд сайн бөгөөд Тэрбээр надад цэц ухаан, мэдлэг, баяр хөөр өгдөг (Ром 15:14, Номлогчийн үгс 2:26).

Би Эзэний хүслийг бүхий л цэц ухаан, сүнслэг ойлголтоор бүрэн дүүрэн мэднэ. Би Христийн доторх шинэ бүтээл, Христ Есүсийн дотор бүтээгдсэн Бурханы их гарын бүтээл. Тиймээс надад Түүний цэц ухаан байдаг бөгөөд Тэр миний шийдвэрийг тушаадаг (Колоссай 1:9, 2Коринт 5:17, 1Коринт 2:16).

Миний Эзэн Есүс Христийн Бурхан Аав миний дотор цэц ухаан, илчлэлийг суулгасан бөгөөд би өөрийнхөө доторх Түүний өвийн алдрын найдварыг болон надаар дамжих Түүний оройгүй аугаа хүчийг мэдэхээр нүд минь гэгээрчээ (Ефес 1:17-19).

БАЯР ХӨӨР

Өнөөдөр би өөртөө болоод бусдад амь авчрах үгийг хэлэх учраас, баяр хөөртэй. Эзэний баяр хөөр миний хүч чадал бөгөөд тийнхүү би надад хүчийг өгөгч Христээр бүгдийг хийж чадна (Сургаалт үгс 15:23, 25:11, Нехемиа 8:10, Филиппой 4:13).

Өнөөдөр миний амнаас ямар ч завхарсан үг яриа гарахгүй. Учир нь би итгэлийн болоод гэгээрлийн үгийг л ярина. Тиймээс үг маань амь амьдрал, баяр хөөрийг авчирна (Ефес 4:29).

Өнөөдөр би Түүний хүчирхэг үгийг хэлэх учраас, амныхаа хариултаас баяр хөөрийг эдлэнэ. Өнөөдөр би Эзэнийхээ баяр хөөрд орж, бусдыг баяр хөөртэй байхад нь туслана. Би бусдад итгэлийн үгийг хэлнэ (Сургаалт үгс 15:23, Матай 25:23, 2Коринт 1:24).

Би зөвт байдлыг хайрлаж, гэм нүгэл, гэм нүглийн үр дагаварыг жигшдэг. Тиймээс миний Бурхан намайг бусдаас дээгүүр баяр хөөрийнхөө тосоор тослосон. Би Эзэнд итгэл найдвараа тавин, хөөрнө. Тэр намайг

хамгаалдаг учраас, би баярлан хашхирна.
Би Түүний нэрд хайртай. Би Түүний дотор
баясна (Еврей 1:9, Дуулал 5:11).

Би Түүний ариун нэрд итгэдэг учраас, зүрх минь
Түүний дотор баясна. Би Эзэнийхээ дотор үлэмж
ихээр баясна. Сэтгэл минь Бурханыхаа дотор
баясна. Учир нь Тэр намайг авралын хувцсаар
гоёсон. Зөвт байдлын нөмрөгөөр нөмөрсөн. Таны
Үг миний баяр хөөр, зүрхний минь баясгалан
болдог. Учир нь би түг түмдийн Эзэн Таны нэрээр
дуудагдсан (Исаиа 61:10, Иеремиа 15:16).

ЭРҮҮЛ МЭНД, БАЯЛАГ

Эзэн Үгээ илгээн, намайг эдгээж, хамаг
сүйрлээс аварсан. Би Эзэнд үйлчилдэг бөгөөд
Тэр хоол ундыг минь ерөөж, миний гэрээс
болон надаас өвчнийг зайлуулдаг. Тэр бидний
бүх өвчнийг эдгээдэг (Дуулал 107:20, Гэтлэл
23:25, Дуулал 103:36).

Есүсийг үхлээс босгосон Түүний Сүнс миний
дотор амьдардаг. Тиймээс Христийг үхлээс
амилуулсан тэр Бурхан миний зуурдын биед хүрч,
бүх өвчин, эмгэгээс дархлаатай болгосон (Ром 8:11).

Миний бүх хэрэгцээ Христ Есүсийн дотор хангагдсан. Учир нь миний Бурхан Өөрийн алдар дахь баялгаар Христ Есүсийн дотор хэрэгтэй бүхнээр минь хангадаг. Христ намайг ядуурлын хараал, өвчин, сүнсний үхлийн хараалаас авран сэргээсэн. Би Абрахамын үр учраас, Бурхан намайг бүх талаар үржүүлж, бүх талаар ерөөсөн. Бурхан намайг элбэг баян болгосон (Филиппой 4:19, Галат 3:13, Еврей 6:14).

Би өгдөг учраас чихсэн, сэгсэрсэн, асгарсан хэмжээгээр дүүрэн дүүрэн хүлээн авна (Лук 6:38).

Өнөөдөр би ажил үйлсдээ баясна. Тэр миний гарын хөдөлмөрийг ерөөнө. Би аз жаргалтай байна. Бидний бүх хэрэгцээг хангадаг Түүгээр дамжин миний гэр бүлийн хэрэгцээ элбэг дэлбэгээр хангагдана (Дуулал 128:1-2, Дэд хууль 12:7, 186).

Эд баялаг миний гэрт оршиж, миний зөвт байдал мөнхөд тогтоно (Дуулал 112:3).

АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА АЙДСААС ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ

Эзэнийг сөрөх цэц ухаан, ойлголт, зөвлөгөө гэж байхгүй учраас, өнөөдөр би болон миний хайртай хүмүүс аюулгүй байна (Сургаалт үгс 21:30).

Би Эзэний Үгээр дуу хоолойг нь сонсдог. Тиймээс би аюулгүй оршин, айдас, ёрын муугаас нам жим байдаг (Сургаалт үгс 1:33).

Миний бие ч, миний хайртай хүмүүс ч харанхуйн хүчээс чөлөөлөгдөөд, Бурханы хайртай Хүүгийн хаанчлал руу орсон. Бидэнд ёрын муу ч тохиолдохгүй, гай гамшиг ч ойртохгүй. Би дайсны айдсын сумыг ялна, намайг юу ч хорлохгүй. Учир нь миний дотор байгаа Бурхан дэлхийд байгчаас аугаа (Колоссай 1:13, Дуулал 91:10, Ефес 6:16, 1Иохан 4:4).

Би зөвт байдал дотор сүндэрлэсэн. Надад айдас байхгүй учраас, дарамт ч байхгүй. Айдас сүйрэл ч надад ойртож чадахгүй. Бурхан надад айдсын сүнсийг бус, хүч, хайр,

эрүүл саруул ухааны сүнснийг өгсөн (Исаиа 54:14, 2Тимот 1:7).

Эзэн миний хамгаалалт, миний цайз, миний Бурхан. Түүнд би найдна. Тэр надад хорт могой, хилэнцэт хорхойг бяцлах, дайсны хамаг хүчээс дээгүүрх хүчийг өгсөн тул намайг юу ч хорлохгүй (Дуулал 91:2, Лук 10:19).

ГЭР БҮЛ

Бурхан миний өмнө амьдрал үхэл, ерөөл хараалыг тавьсан. Тиймээс би өөрөө ч амьдарч, үр удмаа ч амьдруулахын тулд амийг сонгоно. Гэр бүл маань амар амгалан байна гэдгийг би мэднэ. Би эзэмшлээ эргэж тойрон, нүгэл үйлдэхгүй. Мөн миний үр удам аугаа байж, үр сад маань өвс мэт халиурна. Ёрын муу хүмүүс зайлуулагдаж арчигдана. Харин миний гэр бүл байсаар байна (Дэд хууль 30:19, Иов 5:24-25, Сургаалт үгс 12:7).

Би Эзэн Есүс Христдээ итгэх бөгөөд би болон миний гэр бүл аврагдсан (Үйлс 16:31).

Зөвтийн үр удам чөлөөлөгдөнө. Эзэн зөвт

бөгөөд Тэр миний гэр бүл доторх бүх ёрын муу хүлээсийг тасласан (Сургаалт үгс 11:21, Дуулал 129:4).

Үр хүүхэд минь цэцэн цэлмэг бөгөөд сэтгэлийн минь баясгалан болдог. Тэд Эзэний тухай заалгаж, үлэмжийн амар амгаланг эдлэдэг (Сургаалт үгс 27:11, Исаиа 54:13).

Би явах ёстой замаар нь үр хүүхдээ сургадаг. Тийнхүү тэрбээр өтлөсөн ч, энэ замаасаа гажихгүй (Сургаалт үгс 22:6).

Би үр хүүхэддээ Эзэний үгийг зааж, гэртээ сууж байхдаа, замаар алхаж явахдаа, хэвтэж байхдаа, босохдоо Эзэний үгийг ярьдаг. Би үр хүүхэддээ Үгийг хэлж, үр хүүхэд минь үр хүүхэддээ хэлж, тэдний үр хүүхэд нь удаах үедээ заана (Дэд хууль 11:19, Иоел 1:3).

Миний хүү, охин (нэрийг нь дууд) Бурханы сургаалыг марталгүй, тушаалыг нь зүрхэндээ хадгална. Тийнхүү тэдний өдрүүд уртсаж, амьдралынх нь он жил, амар тайван нэмэгдэнэ. Тэд эелдэг зөөлөн чанар, үнэнээс салалгүй, эдгээрийг хүзүүндээ зүүж, зүрхнийхээ толион

дээр бичнэ. Тийнхүү тэд Бурханы бөгөөд хүний нүдэнд таалал, сайн нэрийг олно (Сургаалт үгс 3:1-4).

Бурхан Та миний үр хүүхдийг Тан руу хүргэх замаас хөл алдуулан гаргахгүй. Та тэднийг цурам хийлгүй сахин хамгаална (Дуулал 121:3).

Эзэн Та зөвт бөгөөд биднийг боолчилж байсан Сатаны төмөр олсыг тасласан (нүглээ тоочиж нэрлэ) (Дуулал 129:4).

БОЛЗОЛГҮЙ ХАЙР

Би хуурмаг хайраар хайрлахгүй. Би ёрын мууг жигшиж, сайн зүйлийг хайрлана (Ром 12:9).

Тийнхүү би хайр маань мэдлэгээр хийгээд бүхий л шүүлтээр улам бүр өсөхийн төлөө залбирна. Би мэдлэгийг давсан Христийн хайрыг мэддэг бөгөөд би Бурханы бүхий л элбэг баянаар дүүрэн (Филиппой 1:9, Ефес 3:19).

ХАРИЛЦАА

Аав аа, Та намайг тааллаараа бамбай мэт

хуягладаг учраас, би гэр бүлийнхээ ч,
хамтран зүтгэгч нарынхаа ч, таньдаг мэддэг
хүмүүсийнхээ ч тааллыг олсон тул Тандаа
баярлалаа (Дуулал 5:12).

Аав аа, бид урьд өмнө бие биеийнхээ өмнө юу
ч үйлдсэн байсан - өдгөө Есүсийн загалмайн
цусаар Есүстэй болоод _____-тэй
эвлэрсэн учраас Тандаа баярлалаа (Колоссай
1:20-21).

ЭРХ МЭДЭЛТНИЙ ТӨЛӨӨ

Өнөөдөр би ерөнхийлөгчийнхөө төлөө,
өөрийнхөө дээр эрх мэдэлтэй хүмүүсийн төлөө
залбирч байна. Тэдний зүрх Эзэний мутарт
байж, Эзэн тэднийг хүссэн зүг рүүгээ эргүүлэх
болтугай (Сургаалт үгс 21:1).

Манай үндэстэн, пасторууд, чуулганууд
ерөөгдсөн. Учир нь бидний Бурхан бол Эзэн
бөгөөд бид бол Түүний өвлөхөөр сонгосон
хүмүүс билээ (Дуулал 33:12).

Би ч, Христийн бие ч Бурханаар зөвтгөгдсөн.
Тиймээс би энэ үндэстнийг өргөж, харанхуйн

эрх мэдэл, хүч, захирагч нар, сүнслэг ёрын мууг хүлж, миний улс үндэстэн, чуулган, гэр бүл, миний эсрэг ямар ч эрх хүчгүй болохыг нь Есүсийн нэрээр тунхаглаж байна (2Коринт 5:12, Сургаалт үгс 14:34, Ефес 6:12).



Үгийг тунхагла

Сара Боулинг



“Үгийг тунхаглах” зарчмыг би яс махаараа мэднэ. Тухайлбал, би бага ангид байхдаа, спорт өдөрлөгийг үзэн яддаг байлаа. Яагаад гэвэл би ангидаа биеийн тамиртаа хамгийн муу нь байсан юм. Таван хошуу авах юм бол, дандаа л “дараагийн удаа хичээдэг юм шүү” гэсэн утгатай ногоон таван хошуу л авна. Тиймээс би жилийн жилд хавар болохоор л одоо яана аа хэмээн айдаг байв. Тэгтэл дөрөв байна уу, тавдугаар ангид ээж бид хоёр энэ айдсаасаа бүр мөсөн салахаар шийдэв. Яаж? Үгийг тунхагласнаар. Бид хоёр Библиэс уйлагнах талаар бас сайн гүйцэтгэх талаар заасан гурван ишлэл сонгов. Тэгээд би спорт өдөрлөг болохоос ойролцоогоор хоёр долоо хоногийн өмнөөс тэдгээр ишлэлийг өдөр бүр хэлдэг болов. Тэгтэл яасан гээч? Тэр жил би нэг ч ногоон таван хошуу авалгүй нэг, хоёрдугаар байрын таван хошууг хамсан! Тэр цагаас би Библийн Үг нь миний мэдрэмж, бодол, харааг давсан хүчтэй гэдэгт бат итгэсэн билээ.

Түүнээс хойш өдийг хүртэл Үгийг тунхаглах нь миний амь амьдрал болжээ. Ялангуяа Есүсийг таньж мэдэх нь хичнээн чухал болохыг заадаг, хамгийн дуртай ишлэлүүд маань зүрхний маань угаас байн байн ундран гардаг (Филиппой 3:8-10, Гэтлэл 33:1, Дуулал 25:14). Түүнчлэн би өдөр бүр үр хүүхэдтэйгээ Библийн аль нэг ишлэлийг тунхагладаг. Бурханы Үг ямар хүчирхэг бөгөөд үр нөлөөтэй болохыг Исаиа 55:11, Еврей 4:12-оос би мэднэ. Мөн өөрийнхөө амьдралаар ч мэднэ. Тиймээс энэхүү товхимлыг гар дороо байлгаж, амьдралд тулгарсан нөхцөл байдалдаа өөрийнхөө бодол мэдрэмжээр туугаад байлгүй, харин Бурханы Үгийг тунхагла. Би танд зориулж, өөрийнхөө байнга тунхагладаг ишлэлээ бас дээрээс нь нэмж нилээд олон ишлэлийг орууллаа. Эцэст би таныг энэхүү товхимол дахь ишлэлийг байнга хэрэглэж эхлэхийг хатуу ятгаж байна. Яг өөрт хэрэгтэй Үгийг олохоор Бурханы Үгийг малтах үед Бурханы Үг хамгийн хүчирхэг ажилладгийг би амьдралаараа сурсан. Бурхан хүн болгонтой хувьчилсан, дотно, нарийн харилцаатай байхыг хүсдэг. Бурхан томъёо, системийг бус, харилцаа өөрчлөлтийг хүсдэг. Тиймээс баяртайяа итгэ, баяртайяа ангуучил, Бурхантайгаа баяртайяа нөхөрлө!

ЗОРИЛГО

Бурхан Эзэний маань ивээл Бидэн дээр байх болтугай! Бидний гарын үйлсийг Бидний төлөө бат тогтоогооч! Тийм ээ, гарын маань үйлсийг бат тогтоогооч (Дуулал (90:17)!

Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм (Филиппой 2:13).

АЙДАС ЗОВНИЛ

Ачаагаа ЭЗЭНд даатга, Тэр чамайг түшин тэтгэнэ. Зөвтийн ганхахыг Тэр хэзээ ч зөвшөөрөхгүй (Дуулал 55:22).

Танд итгэдгийн улмаас санаа бат хүмүүнийг Та амрын амар байлгана (Исаиа 26:3).

Бүү ай! Бат зогсож, ЭЗЭНий чөлөөлөхийг харцгаа. Тэр өнөөдөр та нарын төлөө үүнийг гүйцээх болно (Гэтлэл 14:13).

Нүд минь үргэлж ЭЗЭН өөд хардаг Учир нь Тэр миний хөлийг урхинаас суллана (Дуулал 25:15).

БУРХАНТАЙ ТОГТООХ ДОТНО ХАРИЛЦАА

Ингээж итгэлээр Христ зүрхэнд тань нутаглаж, та нар хайр дотор үндэслэгдэн суурилагдаад, тэр хайрын ямар өргөн, урт, өндөр хийгээд гүн болохыг бүх ариун хүний хамт ойлгох болтугай. Мэдлэгийг давдаг Христийн хайрыг мэдсэнээр та нар Бурханы бүх дүүрлээр бялхах болтугай (Ефес 3:17-19).

ЭЗЭНээс эмээхүй нь Мэргэн ухааны эхлэл. Ариун Нэгэнийг мэдэх нь ухаарал (Сургаалт үгс 9:10).

Дахин айдаст хүргэх боолчлолын сүнсийг та нар хүлээн аваагүй, харин үрчлэлийн Сүнсийг авсан билээ. Түүгээр бид «Ааба! Аав аа!» гэж дууддаг (Ром 8:15).

Гагцхүү эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно (Матай 6:33).

Хэрэв бид Сүнсэнд амьд байгаа юм бол мөн Сүнс дотор явцгаая (Галат 5:25).

Найдвар нь биднийг гонсойлгодоггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжин Бурханы хайр зүрхэнд маань цутгагдсан байдаг (Ром 5:5). ЭЗЭН Бурхан чинь чамайг өөрийн Бурхан ЭЗЭНийг

бүх зүрх, бүх сэтгэлээрээ хайрладаг болгохын тулд чиний зүрхийг болоод чиний үр удмын зүрхийг хозолно (Дэд хууль 30:6).

Учир нь үхэл ч, амь ч, тэнгэрэлч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй гэдэгт би бат итгэлтэй байна (Дэд хууль 8:38-39).

Бурханы хүчээр би чамд зааварлана. Төгс Хүчит Нэгэний тухай би юу ч нуугаагүй (Иов 27:11)

ШИЙДВЭР

ЭЗЭНээс эмээдэг хүн хэн юм бэ? Түүнд тэрээр сонгох ёстой замыг нь зааварчилна (Дуулал 25:12).

Миний хоньд дууг минь сонсдог. Би тэднийг таньдаг бөгөөд тэд Намайг дагадаг юм (Иохан 10:27).

Та нар баруун тийшээ эргэсэн ч, зүүн тийшээ эргэсэн ч, араас чинь дуугарах “Энэ бол зам. Үүгээр алхагтун” гэх үгийг чих чинь сонсоно (Исаиа 30:21).

*Би явах ёстой замд чинь чамд зааварлан зааж өгнө
Нүд минь чамайг ширтэн чамд зөвлөнө (Дуулал 32:8).*

ӨӨРТӨӨ ИТГЭХ

*Үгээ илгээн тэднийг эдгээж, Мөхлөөс нь аврав
(Дуулал 107:20).*

*Дуудсан өдөрт минь Та надад хариулав. Сэтгэлийг минь
хүч чадлаар зоригжуулав (Дуулал 138:3).*

*ЭЗЭН миний хүч чадал, миний бамбай. Зүрх минь
Түүнд найдсан билээ, Тусыг нь би хүртсэн билээ.
Тиймээс зүрх минь баярлаж, Түүнд дуугаараа би
талархнам (Дуулал 28:7).*

ГЭР БҮЛ

*Харин би болон манай гэрийнхэн бид ЭЗЭНд
үйлчилнэ гэлээ (Йошуа 24:15).*

*Хамаг хөвгүүн чинь ЭЗЭНээр сургагдана,
Хөвгүүдийн чинь амар тайван нь агуу их болно
(Исаиа 54:13).*

ЯЛАЛТ

*Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд
Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй*

*биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг
(2Коринт 2:14).*

*Чиний эсрэг бүтээгдсэн нэг ч зэвсэг амжилт
олохгүй. Шүүх дээр чиний эсрэг боссон хэл бүрийг
чи яллана. ЭЗЭНий зарц нарын өв нь энэ бөгөөд
Тэдэнд Надаас зөвтгөл ирнэ” гэж ЭЗЭН зарлиг
болгов (Исаиа 54:17).*

*Учир нь зөвт хүнийг ерөөдөг нь ЭЗЭН, Та билээ.
Бамбайгаар халхлах мэт Таалал тань түүнийг
хүрээлнэ (Дуулал 5:12).*

*Харин бид энэ бүхний дотор биднийг хайрладаг
Түүгээр дамжин давуулан дийлдэг (Ром 8:37).*

ҮГЭЭР АМЬДАР ...
ГАЙХАМШГИЙГ ТАЙЛ

ЕСҮСИЙГ АВРАГЧААРАА ХҮЛЭЭН АВ

Библи “Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно” гэж хэлсэн (Ром 10:9).

ЕСҮСИЙГ АВРАГЧААРАА ХҮЛЭЭН АВАХЫН ТУЛД ИНГЭЖ ЗАЛБИРНА УУ:

Есүс ээ, Та миний төлөө үхэж, үхлээс амилсан гэдэгт би итгэж байна. Би нүгэлтэй хүн гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Тиймээс надад Таны хайр, уучлал хэрэгтэй. Амьдралд минь ирж, нүглийг уучилж, надад мөнхийн амь өгөөч. Би Таныг Эзэнээ болгож байна. Намайг аварсанд баярлалаа! Амень.

ГАРЫН ҮСЭГ:

ОГНОО:

*Бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу:
(Өөрийн чуулганы холбогдох хаягийг бичнэ үү)*

ЗАЛБИРЛЫН ХҮСЭЛТ

Та залбирлаа бидэнд илгээнэ үү. Бид таны төлөө залбирах болно. Залбирлын хүсэлтээ доорх зайнд бичээд бидэнд илгээнэ үү.

ЗАЛБИРЛЫН ХҮСЭЛТ:


Бидэнтэй дараах хаягаар холбогдоно уу:
(Өөрийн чуулганы холбогдох хаягийг бичнэ үү)



Мэрилин Хикки Министрийз (Үйлчлэл)

marilynandsarah.org
savingmoses.org

ҮГЭЭР АМЬДАР... ГАЙХАМШГИЙГ ТАЙЛ



Энэ бол Мэрилин,
Сара хоёрын
дуудлага. Биеийн
болоод сүнслэг
хэрэгцээний
төлөө үйлчлэх
нь Мэрилин
Хиккигийн
үйлчлэлийн зүрх
юм.



Мэрилин Хиккигийн охин Сара Боулинг, нөхөр Рииз
Боулингийн хамт.



- Илгээлтийн төсөл
- Хоол хүнсний хөтөлбөр
- Өнчин, орон гэргүй хүмүүст зориулсан халамжлийн үйлчлэл.





Дэлхий даяарх
эдгэрлийн
үйлчлэл болон
Сургалтын
төвүүд...

• Библи • Христитгэлт утга зохиол • 1500 гаруй
төрлийн үйлчлэл • Бидэнтэй **marilynandsarah.org**
цахим хаягаар холбогдоно уу.



- Дэлхий даяар цацагддаг зурагтын хөтөлбөр
- Цахим хуудас
- Залбирлын сүлжээ
- Илгээлтийн аян



**БИДЭНТЭЙ ДАРААХ
ЦАХИМ ХАЯГААР ХОЛБОГДОНО УУ:**

**marilynandsarah.org
savingmoses.org**

би магтан дуулна. ²Таны ариун
и мөргөж Хайр энэрэл, үнэний
Таны нэрд талархахын учир нь
эр бүхнээсээ өндөрт Амлалтаа
снийх. ³Дуудсан өдөрт минь Та
в. Сэтгэлийг минь хүч чадлаар
⁴Аяа ЭЗЭН, амнаас тань гарах
зын бүх хаан Танд талархана
амуудын тухай дуулна Учир нь
аугаа. ⁶ЭЗЭН хэдийгээр өндөрт
нэгнийг хардаг. Бардамнагчийг
руун мутар тань намайг аварна.
хайр энэрэл тань мөнхийн юм.
нхаа бүтээлүүдийг бүү орхиоч.

Үгийг Тунхагла

Бурханы Үгийг тунхаглах шиг чухал зүйл
амьдралд үгүй. Та амьдрал, нөхцөл байдал,
хань ижил, үр хүүхэд дээрээ Бурханы
амлалт үгийг тунхаглах үед өөрчлөлт бий
болдог. Гэтэл бид өдөр тутмынхаа ажил
амьдралд түүртээд, ингэж явах завгүй мэт
санах болжээ. Тэгвэл танд “Үгийг тунхагла”
гэдэг бяцхан ном туслана! Маш энгийн
энэхүү товхимол маань яг одооноос эхлээд
Бурханы Үгээр дамжих сүнслэг хүчийг
ажиллуулахад чинь туслана.